



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 5/44

Чингис хот

Гэрээт ажилтан Ц.Гэрэлтуяад
ур чадварын нэмэгдэл олгох

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн гэрээт ажилтны "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн дөрөвдүгээр үе шатны хүрээнд 2018 оны 1, 2 дугаар улиралд хийсэн ажлын үр дүнгээр нормын биелэлтийг үндэслэн ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Хөдөлмөрийн гэрээ, нормын биелэлтээ сар бүр хангаж ажилласан Архивын тасгийн гэрээт ажилтан архивч-операторч Ц.Гэрэлтуяагийн ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар тооцож 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгосугай.

3. Уг зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны гэрээт ажилчдын цалингийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР